UKaid from the British people

CITA International Motor Vehicle Inspection Committee

THE WORLD BANK

grsf@worldbank.org

bit.ly/GlobalRoadSafetyFacility

МОНГОЛ УЛС УЛААНБААТАР ХОТ

GRSF Global Road Safety Facility

ДДАЗАБС-ГИЙН ТУСЛАМЖИЙН **ОНЦЛОХ** ҮЙЛ АЖИЛЛАГАА

“НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН АЮУЛГҮЙ ДЭД БҮТЭЦ” САНААЧЛАГА

Монгол Улс, Улаанбаатар хот. Дэлхийн банкны Зам, тээврийн баг нь **Даян дэлхийн авто замын аюулгүй байдлын сангийн (ДДАЗАБС) санхүүжилттэй хэрэгжиж буй техникийн тусламжийн хүрээнд** нийслэл хотын авто замын аюулгүй байдлын асуудлыг зам, тээврийн дэд бүтцийн хөрөнгийн төлөвлөлт, менежментэд тусган хэрэгжүүлэх чиглэлээр Нийслэлийн авто замын хөгжлийн газар болон Тээврийн цагдаагийн газартай хамтран ажиллаж байна.

ДДАЗАБС-гийн туслалцаа нь Даян дэлхийн гамшгийн эрсдлийг бууруулах, сэргээх сангийн (ДДГЭБСС) санхүүжилттэй хэрэгжиж буй замын хөдөлгөөний аюулгүй байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдлийг тусгасан, үр ашигтай, системтэй зам, замын байгууламжийн хөрөнгийн тооллогын бүртгэл, хөрөнгийн менежментийн мэдээллийн системийг нэвтрүүлэх төсөлтэй хамт хэрэгжиж байгаа болно.

ДДАЗАБС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДДАЗАБС-гийн дэмжлэгтэйгээр, замын хөдөлгөөний аюулгүй байдалд нэн чухал үүрэгтэй нийслэлийн авто замын босоо тэмдэг, хэвтээ тэмдэглэгээ, гудамж, замын гэрэлтүүлэг зэрэг авто замын дэд бүтцийн үндсэн хөрөнгө дутмаг байгаа хэсгүүдийг харгалзах өнгөөр кодлон газрын зурагт харуулах ажил хийгдээд байна.



Mapilliary ашиглаж хийсэн Улаанбаатар хотын замын сүлжээний зураглал



Mapilliary-гийн автомат обьект танигч ашиглаж хийсэн Улаанбаатар хотын автозамын сүлжээний босоо тэмдгийн зураглал

Энэхүү мэдээлэл нь **замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, эрсдлийг хамгийн доод түвшинд хүргэх зорилгоор нийслэл хотод хийх замын засвар, арчлалтын ажлуудыг эрэмбэлэхэд ашиглагдах мэдээллээр хангах зориулалттай** нийслэлийн замын дэд бүтцийн газарзүйн байршлын тэмдэглэгээтэй хөрөнгийн тооллогын бүртгэлд тусгагдсан болно.

Автозамын аюулгүй байдлын эрсдлийн зураглалыг хийснээр, **Нийслэлийн автозамын хөгжлийн газрын зүгээс** нийслэлийн авто замын сүлжээн дэх замын босоо тэмдэг, хэвтээ тэмдэглэгээг сайжруулах, өндөр эрсдэлтэй автозамын хэсэгт (жишээлбэл, зам, тээврийн осол их гардаг хэсэг) дутагдалтай байгаа замын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх зэрэг **хамгийн үр ашигтай арга хэмжээнд хязгаарлагдмал нөөцийг хуваарилах боломж бүрдэнэ.**

ДДАЗАБС-гийн санхүүжилттэй техникийн тусламжийн хүрээнд, мөн автозамын дэд бүтцийн аюулгүй байдлын инженеринг болон автозамын аюулгүй байдлын аудитын чиглэлээр хамтран ажиллагч талуудын **чадавхийг бэхжүүлэх дэмжлэг** үзүүлээд байна. Дэлхийн банкны Зам, тээврийн баг нь 2018 оны 10-р сараас эхлэн Нийслэлийн авто замын хөгжлийн газар болон Тээврийн цагдаагийн албанд зориулан цуврал сургалт, семинар болон газар дээрх үзлэгийн ажлыг зохион байгуулаад байна.

Монгол Улсын Улаанбаатар хот дахь “Нийслэлийн авто замын аюулгүй дэд бүтэц” санаачлага нь **авто замын дэд бүтцийг хэрэглэгчдэд аюулгүй байлгахад оролцох авто замын инженер, зураг төсөл боловсруулагчдын үүрэг оролцоог тээврийн цагдаагийнхны үүрэг, оролцооны нэгэн адил чухал ач холбогдолтой гэж үздэг болох алсыг харсан өөрчлөлтийг авчрах боломж бүрдүүлж байгаа юм.**

Дэлхийн банкны Зам, тээврийн багт, Монгол Улсын Тээврийн цагдаагийн албанаас, Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд хамтран ажиллаж, хувь нэмрээ оруулсанд нь талархан дурсгалын цом гардуулсан.

“Нийслэлийн авто замын аюулгүй дэд бүтэц” санаачлагын үйл ажиллагаанд**, Их Британийн “UK Aid”, Олон улсын авто тээврийн хэрэгслийн хяналтын хороо (CITA) болон Дэлхийн банкны зүгээс ДДАЗАБС**-аар дамжуулан дэмжлэг үзүүлж байна.

Төслийн баг: Филипп Жордан, Дашийн Баттуяа, Бат-Оригийн Халиун, Анника Берлин, Зиминг Лью, Азеб Афевөк, Дамдиндоржийн Дэжидмаа, Янг Чен (Техникийн багийн ахлагч).